



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 26

Улаанбаатар »

### XXVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын 26-р хуралдаан 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 10:00 цагт Төрийн ордны Шадар сайдын хурлын өрөөнд 90 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн шинэчилж байгаа талаар мэдээлэл хийх;

*Монгол Улсын Шадар сайд  
Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар*

2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдлын мэдээ танилцуулах;

*Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн*

3. Гадаад улсаас Монгол Улсын иргэдийг татан авах ажиллагааны талаар танилцуулга;

*Гадаад харилцааны яамны  
Консулын газрын захирал Л.Мөнхтүшиг*

4. Үер, тарваган тахлын нөхцөл байдлын мэдээний талаар танилцуулга;

*Онцгой байдлын ерөнхий газрын  
Тэргүүн дэд дарга, бригадын генерал Г.Ариунбуян*

5. Бусад;

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

А. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс 31-ний өдрийг дуустал хугацаанд сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр тогтов.

Нэг. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,  
Цагдаагийн ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,  
Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр  
орлогч Ж.Батбаясгалан нарт:

1.1. Нийслэлийн онцгой комиссоос гаргасан шийдвэрийн хүрээнд үйлчилгээний байгууллагуудад КОВИД-19 цар тахлаас сэргийлэх, халдвар, хамгаалаллын дэглэм, цагийн зохицуулалт, зохих дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт шалгалт явуулах;

Хоёр. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,  
Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан нарт:

2.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх салбар дундын дараагийн шатны эрсдэлийн үнэлгээг 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор багтаан хийх;

Гурав. Батлан хамгаалахын сайд,  
Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр,  
Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,  
Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,  
Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан нарт:

3.1. Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад үүргээ гүйцэтгэсэн цэргийн багийн 11 дүгээр ээлжийн хамгаалалтын ротыг татан авах, тусгаарлах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх ажиллагааг зохион байгуулах;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүд,  
Аймаг, Нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

4.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, иргэд, олон нийтэд сурталчлах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдвар, хамгааллын дэглэм, зөвлөмжийг мөрдүүлэх, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх;

Тав. Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгаланд:

5.1. Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх, үерийн далан, ус зайлуулах хоолой шугамыг шалгаж, цэвэрлэгээ, засвар үйлчилгээг хийх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, иргэдэд үер, усны аюулаас сэрэмжлүүлэх мэдээллийг тогтмол хүргэх, Нийслэл Улаанбаатар хот дахь үерийн усны асуудлаар тусгай ажлын хэсэг байгуулж, холбогдох цогц арга хэмжээний саналаа Засгийн газрын хуралд танилцуулахаар бэлтгэх;

Зургаа. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,  
Аймаг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нарт:

6.1. Болзошгүй үер усны аюул, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх хүрээнд айл өрхийн нүхэн жорлонг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах;

Долоо. Ховд аймгийн Засаг дарга бөгөөд Аймгийн онцгой комиссын дарга  
Б.Дүгэржавт:

7.1. Тарваган тахалтай холбоотой үүсээд буй нөхцөл байдалтай уялдуулан аймгийн хэмжээнд зохион байгуулж буй хорио, цээрийн дэглэмийг үргэлжүүлэх, голомтыг эрүүлжүүлэх, хууль бус ан агнуурт тавих хяналтыг чангатгах;

ДАРГА,  
ШАДАР САЙД



Я.СОДБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.САНЖАА